



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 21 он 01 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 1001/30

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд Монгол Улсын Засгийн газраас зохих дэмжлэг үзүүлж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: .9 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.ПҮРЭВДОРЖООС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Монгол Улсад 2018 оны байдлаар бүртгэлтэй 170,166 аж ахуй нэгж бий. Үүнээс 85,749 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 68 хувь буюу 58,602 нь жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамаарч, нийт 1,256,356 ажиллах хүчний 77 хувь буюу 963,146 мянган хүн ажиллаж байна. Засгийн газрын хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын хамгийн их ажлын байрыг бий болгож, эдийн засгийг нуруундаа үүрч явдаг жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж, хичнээн ажлын байрыг хадгалж чадсан бэ?

Монгол Улсын Засгийн газар Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Жижиг, дунд бизнесийг дэмжих, ажлын байрыг хадгалах чиглэлээр:

1. 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр болсон. Улмаар, 2020 онд 104,400 жижиг, дунд аж ахуйн нэгж уг татварын дэмжлэгт хамрагдаж, 78.9 тэрбум төгрөгийн албан татвараас чөлөөлөгдөхөөр байна;

2. Энэ оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 3 сарын хугацаанд үйл ажиллагаа нь зогссон болон борлуулалтын орлого нь 50-иас дээш хувиар буурсан аж ахуйн нэгжүүдийн ажилтан бүрийн тоогоор сар бүр 200,000 төгрөгийг тухайн аж ахуйн нэгжид дэмжлэг болгон олгосон. Энэхүү арга хэмжээний үр дүнд 7,284 аж ахуйн нэгжийн 220,852 даатгуулагчдад давхардсан тоогоор 44.2 тэрбум төгрөгийн дэмжлэг олгосон байна;

3. Даатгуулагч иргэн болон аж ахуйн нэгжийг нийт 715.5 тэрбум төгрөгийн шимтгэл төлөх үүргээс чөлөөлж, энэхүү чөлөөлсөн шимтгэлийг төрөөс иргэд, аж ахуйн нэгжийн өмнөөс хариуцаж байна. 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 6 сарын хугацаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, хувийн хэвшилд ажилладаг иргэд болон сайн дураар даатгуулагчдын төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлж, 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс энэ оныг дуустал 3 сарын хугацаанд шимтгэлийн хувийг 5 болгон хөнгөлж, 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 6 сарын хугацаанд шимтгэлийн хувь хэмжээг 8.5 хувь болгон хөнгөлнө. Энэ арга хэмжээний үр дүнд энэ онд 38,602 аж ахуйн нэгж, 572,007 даатгуулагч хамрагдаж, 715.5 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдөж байна;

4. 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 6 сарын хугацаанд хувийн хэвшилд ажиллаж байгаа иргэдийн цалинг Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлсөн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 889,356 татвар төлөгчийн 198.9 тэрбум төгрөгийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлсөн байна;

5. Татвар төлөгчийн 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй татварт тооцох алданги, торгуулийг чөлөөллөө. Улмаар энэ чөлөөлөлтийг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл сунгахаар хуулийн төслийг боловсруулан Улсын Их хуралд өргөн мэдүүлж, батлуулсан. Энэхүү арга хэмжээний үр дүнд давхардсан тоогоор 356,233 татвар төлөгчийг 2020 онд 48.2 орчим тэрбум төгрөгийн татварын алданги, торгуулиас чөлөөлөхөөр байна. Ажлын байрыг хадгалах, бизнесийг дэмжсэн дээрх арга хэмжээ нь жижиг, дунд бизнесээс бусад иргэд, аж ахуйн нэгжүүд ч хамрагдсан.

Үндэсний статистикийн хорооноос улирал тутам гаргадаг Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээллээр хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын тоо 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 1,175.9 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өссөн байна.

6. Засгийн газраас “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 183 дугаар тогтоолыг баталсан бөгөөд 2020 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан төсөл хүлээн авах үйл ажиллагааг орон даяар зохион байгуулж нийт 1579 төсөл 238,4 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт хүлээн авч Орон нутгийн 156 төсөлд 10,5 тэрбум төгрөг, бичил ангилалын 85 төсөлд 11,1 тэрбум төгрөг, Жайкагийн төслөөс Жижиг, дунд ангилалын 3 төсөлд 2,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүллээ. Үүний үр дүнд 480 ажлын байр шинээр нэмэгдэж, 1225 ажлын байр хадгалагдаж үлдэнэ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-373 дугаар тушаалаар ЖДҮХС-ийн шууд болон банкаар дамжуулан олгосон “хэвийн зээл”-ийн үндсэн зээлийн төлбөр болон хүү төлөх хугацааг 2020.07.01 хүртэл хойшлуулахаар шийдвэрлэсэн. Мөн энэ хугацаанд төлбөрөө барагдуулсан бусад зээлдэгчдийн төлбөр төлөх хугацааг дээрх хугацаагаар хойшлуулах боломж бүрдсэн.

Томоохон зах болон үйлчилгээний төвүүдэд худалдаа хийдэг иргэдээ дэмжих чиглэлээр: Аймаг, нийслэл, сум, дүүргийн томоохон зах болон үйлчилгээний төвийн хүнсний хангамж, нийлүүлэлт, нөөцийн талаарх бодит мэдээг 4 хоног тутамд гаргаж, энэхүү мэдээлэлд тулгуурлан бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай төлөвлөн ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 142 дугаар тушаалаар "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам"-ыг баталсан бөгөөд www.teeverzuuch.mn цахим мэдээллийн сангаар хот дотор, хот хооронд, импорт, экспортын авто тээврийг QR код ашиглан шуурхай зохион байгуулж ажилласан. Ингэснээр томоохон зах болон үйлчилгээний төвийн хүнс, нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт тогтвортой хэрэгжиж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар Мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг хот хооронд тээвэрлэх ажлыг томоохон зах, худалдааны төвийг түшиглэн

өвлийн идэшний тээвэр, түгээлтийг зохион байгуулж байна.

Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн динамикт дүн шинжилгээ хийж, цар тахлын хөл хорионы хугацаанд бүтээгдэхүүнээ тогтвортой үнээр нийлүүлэх уриалгыг гаргаж, үндэсний томоохон үйлдвэрлэгчид дэмжин ажиллаж байна.

Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслүүдийг Улсын Их хурлаар яаралтай горимоор хэлэлцүүлэн УИХ-ын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар баталсан.

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх бүтээгдэхүүний жагсаалтыг батлах Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор баталсан. Эдгээр барааны импортлогч, борлуулагч аж ахуйн нэгжтэй барааны хангамж, үнийг тогтвортой байлгахад бодлогын гэрээ байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр хадгалах чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар ажил хайгч иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогчид зориулан ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах үйлчилгээ үзүүлж байгаа ба хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, санхүүгийн дэмжлэг олгох, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт олгох зэрэг арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнүүдэд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор хүн амын зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг тус тус баталсан.

Дээрх хөтөлбөрүүдэд 2019 оны эцэст давхардсан тоогоор 74761 иргэнийг хамруулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 30,5 сая төгрөгийг зарцуулж, 31994 байнгын болон түр ажлын байр бий болсон ба 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 25067 иргэнийг хамруулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 17,7 сая төгрөгийг зарцуулж, 17850 байнгын болон түр ажлын байр бий болсон байна.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил аж ахуйн нэгжид ажиллагчдын ажлын байрыг хадгалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

- ХЭДС-гаас 2017-2020 онуудад эргэн төлөгдөх нөхцөлтэй, барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэг авсан нийт 12.6 мянга хүний 2024 он хүртэл эргэн төлөх гэрээтэй 36.9 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацааг иргэн, аж ахуй нэгжийн өөрийн хүсэлтэд үндэслэн 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулах;
- Мөн сангаас 2019-2020 онуудад санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан нийт 8154 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ажлын байрандаа түрээс төлдөг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 11, 12 дугаар сарын түрээсийн зардалд сар бүр 150.0-250.0 мянган төгрөгийг нөхөн төлөх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарим хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг авсан, эргэн төлөлт нь дуусаагүй байгаа иргэдэд өөрийн хүсэлтийг нь үндэслэн өмнө ирүүлсэн төсөлд дутуу олгосон нэмэлт санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх нөхцөлтэйгээр олгохоор тус тус шийдвэрлэсэн.

Дээрх арга хэмжээнд нийт 16.5 мянга орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж, үр шим хүртэх боломжтой бөгөөд түрээсийн дэмжлэг үзүүлэх болон нэмэлт санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд нийт 1.5 тэрбум төгрөг зарцуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн А/228 дугаар бүхий “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай” тушаалаар шийдвэрлэж, харьяа байгууллагуудад хуваарилан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эдгээр арга хэмжээ нь өдрийн орлогоор амьдрал, ахуйгаа зохицуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус эдийн засгийн салбарт ажиллагч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэднийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагуудын тодорхой хувьд чухал дэмжлэг болно гэж үзэж байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хуулийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар баталсан.

2020 оны 4-9 сарын нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтөд 38.4 мянган ажил олгогч, тэдгээрт ажиллаж байгаа 410.6 мянган даатгуулагч, сайн дурын 156.5 мянган даатгуулагч хамрагдаж, нийт дүнгээр 566.8 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдсөн байна. Тухайлбал:

- ✓ Нийт шимтгэлийн чөлөөлөлтийн 74.8 хувийг 31.8 мянган хувийн хэвшлийн аж ахуйн нэгж (ХХК), тэдгээрт ажиллаж байгаа 388.4 мянган даатгуулагч, 13.2 хувийг 1.9 мянган гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, тэдгээрт ажиллаж байгаа 42.3 мянган даатгуулагч тус тус эдэлсэн байна.
- ✓ Дунджаар албан журмын даатгуулагч 513.8 мянган төгрөгийн, сайн дураар даатгуулагч 322.9 мянган төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдсөн.

2020 оны 4-6 сард ажилгүйдлийн даатгалын сангаас 7.3 мянган ажил олгогчийн 80.9 мянган даатгуулагчид дэмжлэг олгосон. Тухайлбал:

- ✓ Эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь зогсоосон 5844 аж ахуйн нэгжийн 64.2 мянган даатгуулагчид 35.6 тэрбум төгрөгийн дэмжлэг олгов.
- ✓ Борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан 1420 аж ахуйн нэгжийн 16.7 мянган даатгуулагчид 9.3 тэрбум төгрөгийн дэмжлэг олгов.

2020 оны 10-12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 39.0 мянган ажил олгогч, 493.3 мянган албан журмын даатгуулагч, 162.9 мянган сайн дураар даатгуулагч хамрагдаж, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 3.5 хувиар, тэтгэмжийн, ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлснөөр ажил олгогч, даатгуулагч нийт дүнгээр 146.4 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдөнө.

Харин 2021 оны 1-6 сар тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1.0 хувиар, тэтгэмжийн, ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлснөөр 39.0 мянган ажил олгогч, 493.3 мянган албан журмын, 162.9 мянган сайн дураар даатгуулагч хамрагдах бөгөөд нийт дүнгээр 198.9 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдөх юм.

Түүнчлэн, 2020 оны 2, 3 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа үнэн зөв ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Энэхүү арга хэмжээнд 6.2 мянга орчим аж ахуйн нэгж, байгууллага 13.9 тэрбум төгрөгийн торгох шийтгэл, алдангиас чөлөөлөгдсөн.

Засгийн газраас ажил олгогч, даатгуулагчийг дэмжих зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд шимтгэл төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг Зөрчлийн тухай хуульд заасан торгох шийтгэл, алдангиас чөлөөлөхөөр “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай” хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж уг хуулийн төслийг Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан.

Ингэснээр 2020 оны 4 сараас 2021 оны 6 сар хүртэл хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн үйлчлэлд 39.0 мянган ажил олгогч, 656.2 мянган даатгуулагч хамрагдаж нийтдээ 912.2 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдөх мөн 10.0 мянган орчим шимтгэл төлөгч 44.0 тэрбум төгрөгийн торгох шийтгэл, алдангиас тус тус чөлөөлөгдөх юм.

Ийнхүү төрөөс шимтгэлийн чөлөөлөлт, хөнгөлөлтийг үзүүлснээр ажил олгогчид санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлэх, даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа тасрахгүй байх, улмаар нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Асуулга 2. Үсчин, машин засвар, машин угаалга, томоохон зах болон үйлчилгээний төвүүдэд гар дээрээс худалдаа хийдэг иргэд, оёдолчид гэх зэрэг өдрийн орлогоороо өрхийн амьдралаа, өнөө маргаашийн хоолоо залгуулж буй 180 мянган иргэдээ дэмжихэд хэдэн төгрөг зарцуулсан бэ?

Томоохон зах худалдааны төвд талбай түрээслэн бизнес эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжийн түрээсийн төлбөрийг бууруулах зорилгоор 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжид ийнхүү бууруулсан дүнтэй тэнцэх орлогын албан татварын хөнгөлөлт үзүүллээ. Энэ арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл сунгахаар хуулийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулсан. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2020 онд 3,400 орчим түрээслэгчийн 18.8 гаруй тэрбум төгрөгийн түрээсийн төлбөр буурах урьдчилсан дүн мэдээтэй байна.

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан томоохон зах худалдааны төвүүдэд зай талбай түрээслүүлэгч “Нарантуул трейд” ХХК, “Хүчит шонхор” ХХК, “Да Хүрээ Трейд” ХХК, “Ньюком проперти” ХХК зэрэг компаниуд түрээсийн төлбөрөө бууруулсан. Орлого багатай, хувиараа бизнес эрхэлж буй иргэд цар тахлын үед иргэдийн орлогыг дэмжих Засгийн газрын хэрэгжүүлсэн бусад хөтөлбөрт хамрагдсан.

Асуулга 3. Монгол Улсад нийт 897,427 өрх байна. Үүнээс хүүхэдтэй 531,000, хүүхэдгүй 366,427 өрх байдаг. Хүүхэдгүй өрхүүд цар тахлаас сэргийлэх Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хөтөлбөрт хэрхэн хамрагдсан талаар тодорхой мэдээлэл өгнө үү.

Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлсэн нь өрхийн орлогыг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргаа, эмзэг бүлгийн иргэд, гэр бүлийг дэмжих бодлого болно. Хүүхдийн мөнгөн дэмжлэгээс бусад Засгийн газрын авч хэрэгжүүлсэн багц арга хэмжээнд хүүхэдгүй гэр бүл хамрагдсан. Тухайлбал, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл чөлөөлөлтөд гэр бүлгүй өрхийн гишүүд хамрагдах боломжтой.

Түүнчлэн, өрх айл, иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, орлогыг хамгаалах зорилгоор Засгийн газар 2020 оны 12 сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд 870 гаруй мянган айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, эрчим хүч, дулаан хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөхөөр шийдвэрлээд байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор 18 хүртэлх насны хүүхэд бүрд олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд сар бүр 100 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлж олголоо. Уг арга хэмжээнд 2020 оны 12 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1,2 сая хүүхэд хамрагдаж, нийт 9 сарын хугацаанд 1060.4 тэрбум төгрөг зарцуулсан байна. Түүнчлэн цар тахлын үед гадаадад оршин сууж байгаа Монгол Улсын иргэний хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохоор Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 31 тэмдэглэлээр үүрэг болгосны дагуу нийт 5430 хүүхдийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулав.

Иргэдийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн дээрх арга хэмжээг 2021 оны эхний хагас жил дуустал 100 мянган төгрөгөөр үргэлжлүүлэн олгох, сүүлийн хагас жилд 20

мянган төгрөгөөр олгохоор тооцож Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд 864 тэрбум төгрөгийн хөрөнгийг тусган шийдвэрлэсэн.

Цар тахлын нөхцөл байдал цаашид үргэлжлэх төлөвтэй байх бол ирэх он дуустал 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж олгоход шаардагдах хөрөнгийг 2021 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлэх боломжтой юм.

Харин 0-18 насны хүүхэдгүй, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй эмэгтэй 55 нас, эрэгтэй 60 нас хүрсэн ахмадууд олгох халамжийн тэтгэврийг 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх нийт 14 сарын хугацаанд сар бүр 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 288.0 мянган төгрөг олгох юм. Уг арга хэмжээнд 2020 оны 12 сарын байдлаар нийт 59.4 мянган хүн хамрагдаж, нийт 8 сарын хугацаанд 122.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн насанд хүрсэн гишүүн, хүүхдэд олгох хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг 5-8 сарын хугацаанд 2 дахин нэмэгдүүлж тус тус олголоо. Уг арга хэмжээнд нийт 43.2 мянган өрхийн 241.9 мянган иргэн хамрагдаж, дээрх хугацаанд нийт 44.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой хүнсний дэмжлэг зайлшгүй шаардлагатай 43.2 мянган өрхөд хүнсний дэмжлэг, 13.4 мянган өрхөд хүнсний бус дэмжлэг, 10 мянган өрхөд (нэг өрхөд 2 сарын хэрэглээ буюу 933 кг) сайжруулсан түлш тараах ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын болон аж ахуйн нэгж байгууллагатай хамтран зохион байгуулаад байна. Гэр орон гэргүй, ганц бие, тэнэмэл иргэдийг илрүүлж, гэрээт 6 төрийн бус байгууллагад болон Нийслэлийн нийгмийн хамгааллын тусгай төвд нийт 420 иргэнийг байрлуулж, үзлэг шинжилгээ, ариун цэврийн халдвар хамгааллыг сахиулан ажиллав.

Асуулга 4. Монгол Улс зээлийн хүүгийн түвшнээр дэлхийд дээрээсээ 10 дугаар байрт жагсдаг. Арилжааны банкны зээлийн дундаж хүү 17%, хадгаламж зээлийн хоршооны зээлийн дундаж хүү 34.8%, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн дундаж хүү 37.2%, ломбардны зээлийн дундаж хүү 42% байна. 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаас 23 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын Ерөнхий сайд ч хэвлэлийн хурал дээр Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нартай тохиролцсон учраас 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл иргэдийн бүх зээл хойшлогдсон талаар мэдээлэл хийсэн. Гэвч Монголбанкны удирдлага, арилжааны банкууд, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагууд энэ шийдвэрийг янз бүрээр тайлбарлан хэрэгжүүлж байна. Засгийн газрын хуралдааны шийдвэр хүчин төгөлдөр байгаа эсэх талаар мэдээлэл өгнө үү.

Уг асуулгатай холбоотой мэдээллийг Монголбанкны 2020 оны А-1/1455 тоот албан бичгээс үзнэ үү.

Асуулга 5. Хэдхэн сарын өмнө Улсын Их Хурлын сонгуулийн өмнө нэг кг ямааны ноолуурт 20 мянган төгрөгөөр тооцож, 178 тэрбум төгрөгийг бэлнээр

тараасан Засгийн газар нийтээр хөл хорио тогтоосон эдгээр өдрүүдэд иргэдэд 180 тэрбум төгрөг олгох боломжгүй гэсэн шалтгаанаа тайлбарлана уу?

Засгийн газар цар тахлын үед малчдын амьжиргаа орлогыг дэмжих зорилгоор 203.4 мянган малчдад 175.0 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон. Засгийн газар цар тахлын үед иргэд аж ахуйн нэгжийн татвар, шимтгэлийг бууруулж, эмзэг бүлгийн иргэд, олон хүүхэдтэй айл өрхийг дэмжих зэрэг нийгмийн хамгааллын олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 1 жил 3 сарын хугацаанд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2020 онд нийт 1.2 сая хүүхдэд 1,060.4 тэрбум төгрөг олгосон.

Асуулга 6. Монгол Улсын төсвийн орлогын тал хувьд хүрэхүйц буюу 1.7 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний татвар төлөгчдийн асар их хэмжээний хөрөнгө зарцуулсан хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнгийн талаар:

Засгийн газрын зүгээс Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, амьжиргаа, орлогыг дэмжих, ажлын байрыг хадгалах, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, эдийн засгийн хүндрэлээс сэргийлж, эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байгаа бөгөөд иргэдэд үзүүлдэг халамж, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээнд 2020 онд 2,375.0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.

-----oOo-----



Г МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2020. 12. 22 № А-1/1455
танай _____-ны № _____-т

Г Хариу хүргүүлэх тухай

Таны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн ХЭГ/2911 тоот албан бичиг, хавсралтаар ирүүлсэн Монгол Улсын Их хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тодруулгатай танилцлаа.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу Монголбанкнаас банкны зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор доорх зохицуулалтыг хийсэн бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн, 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн тус тус тушаалаар банкуудад 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал ипотек болон иргэн, хуулийн этгээдийн зээлийн бүтцийг өөрчилж, эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах үүргийг өгсөн.

Банкны салбарын хэмжээнд 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийт 4.2 их наяд төгрөгийн 132,108 зээлийн бүтцэд өөрчлөлт оруулж, эргэн төлөлтийн хугацааг хойшлуулсан бөгөөд үүнээс 2.3 их наяд төгрөгийн 45,043 зээл нь орон сууцны ипотекийн зээл, 1.9 их наяд төгрөгийн 87,065 зээл нь бусад зээл байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 183 дугаартай тогтоолын 8-д заасан зөвлөмжийн дагуу банкны нийгмийн хариуцлагын хүрээнд зээлийн бүтцийг өөрчлөхдөө зээлдэгчийн хүсэлтийг харгалзан нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги тооцохгүйгээр, төлбөрийн чадварт нь нийцүүлэхийг үүрэг болгож, зээлийг хугацааны үзүүлэлтээр дүгнэж, ангилахдаа Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хоног (11 дүгээр сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 14-ний өдрүүд буюу 33 хоног)-ийг хасаж тооцох зохицуулалтыг нэмсэн.

Банкууд тушаалаар өгөгдсөн үүргийн дагуу дээрх зохицуулалтыг мөрдөж, зээлдэгчийн хүсэлтийн дагуу эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах, зээлийн бүтцийг өөрчлөх үйл ажиллагааг шийдвэрлэн ажиллаж эхэлсэн болно.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1 А 4373